

**“МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2014 ОНД ХӨГЖҮҮЛЭХ
ҮНДСЭН ЧИГЛЭЛ”-ИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААР НИЙГМИЙН БОДЛОГО,
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ БАЙНГЫН ХОРООНООС ГАРГАСАН
САНАЛ, ДҮГНЭЛТ**

2015 оны 4 дүгээр
сарын 07-ны өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн А.Тлейхан

Эдийн засгийн байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

“Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2014 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-ийн хэрэгжилтийг Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо 2015 оны 4 дүгээр сарын 07-ны өдрийн хуралдаанаар хэлэлцээд гаргасан санал, дүгнэлтийг хүргүүлж байна.

Уг асуудлыг хэлэлцэх үеэр Улсын Их Хурлын гишүүн А.Бакей, З.Баянсэлэнгэ, Г.Баярсайхан, Ё.Отгонбаяр, Д.Сарангэрэл, А.Тлейхан, Д.Хаянхярваа, Л.Энх-Амгалан нар эмийн бүртгэл, хяналтыг сайжруулж, чанартай, сонголт хийх боломж бүхий эмээр үйлчлэх, эм хангамжийн төсвийг нэмэгдүүлэх, эмнэлгийн тусламж, үйлчилгээг сайжруулах, хүн амыг өвчин, эмгэгээс урьдчилан сэргийлэх ажлыг идэвхжүүлэх, багш, эмч нарын нийгмийн баталгааг хангах, аймгуудад байгуулсан орчин үеийн оношилгооны төвүүдийг ашиглалтад оруулах, ахмад настны тэтгэврийн зээлийн хүүг бууруулах, хөдөлмөр эрхлэлт, цалин хөлсний тогтолцоог шинэчлэх, багш нарыг зөөврийн компьютерээр хангах, цэцэрлэг, бага ангийн багш нарын ажлын ачааллыг бууруулах зэрэг асуудлаар Эрүүл мэнд, спортын, Хөдөлмөрийн, Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамдын болон Үндэсний Аудитын газрын төлөөллөөс асуулт асууж, хариулт авлаа.

Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүд жил бүрийн үндсэн чиглэлд хэрэгжих боломжгүй, төлөвлөгөөгүй, тунхагийн шинжтэй зорилтууд тусгадаг, түүнийг нь Улсын Их Хурал ёс төдий байдлаар хэлэлцдэг, 2014 онд 104 арга хэмжээ, хөтөлбөр тусгаснаас 30 хувийн буюу хангалтгүй үр дүнтэй байгаа хэдий ч хариуцлага тооцох эзэн байхгүй, төлөвлөх, хэрэгжүүлэх, хянах зэрэг шатанд төрийн байгууллагууд уялдаа холбоогүй, хэрэгжсэн ажлын жагсаалтад хэрэгжээгүй ажлыг оруулан тооцсон, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн стандартыг Засгийн газар солигдох бүрт өөрчилж байгаа зэрэг алдаа дутагдал байгааг шүүмжилж үг хэллээ.

Түүнчлэн “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2015 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-ийг өмнөх Засгийн газар боловсруулж, батлуулсан, дараа жил мөн л ийм асуудалтай тулгарах тул Байнгын хороо анхаарлаа хандуулж, дорвитой арга хэмжээ авах тухай саналыг гишүүд гаргаж байлаа.

Иймд “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2014 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлттэй холбогдуулан гарах Улсын Их Хурлын тогтоолд тусгуулахаар дараах саналуудыг хүргүүлж байна.

1. Үндсэн чиглэлийн хэрэгжилтийг хангалтгүй гэж дүгнэх;

2. Үндсэн чиглэлийн зорилтуудыг төлөвлөх, хэрэгжүүлэх, биелэлтийг дүгнэх, хариуцлага тооцдог аргачлал, стандартыг шинэчилж боловсруулах тухай Засгийн газарт хугацаатай үүрэг өгөх;

3. Үндсэн чиглэлд хэрэгжих боломжтой, бодитой ажлуудыг тусгаж, салбар яамдууд гүйцэтгэлээ хэмжиж болох шалгуураар тодорхой, нарийвчлалтай гаргадаг байх;

4. Үндэсний Аудитын газар нь гүйцэтгэлийн аудитын тайлангаа тодорхой болгох, хэрэгжээгүй арга хэмжээг эзэнтэй болгож, хариуцлага тооцох тухай санал оруулж ирдэг байх;


5. Үндсэн чиглэлийг тухайн оны төсөвтэй уялдуулан хэлэлцдэг болох, төсөвт тодотгол хийхдээ үндсэн чиглэлд мөн адил тодотгол хийдэг байх;

6. Үндсэн чиглэлийн хэрэгжилтийг жил бүр ёс төдий хэлэлцэж байгаатай холбогдуулан үндсэн чиглэл хэлэлцдэг дэгийг өөрчилж, тодорхой болгох;

7. "Төрөөс эмийн талаар баримтлах бодлого"-ын 9.1.1, 9.1.2-д заасны дагуу иргэдийн эрүүл мэндийг хамгаалах зорилгоор эмийн асуудал хариуцсан тусгай агентлагийг одоогийн бүтэц, орон тоондоо багтаан байгуулах.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**НИЙГМИЙН БОДЛОГО, БОЛОВСРОЛ,
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА**



Д.БАТЦОГТ